

ШИВЭЭГОВЬ СУМЫН 2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

2024.06.24

Шивээговь сум

НЭГ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Сумын Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулж, сумын Засаг даргаас 5 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Сумын Засаг даргын Зөвлөлийн хурлыг 06 дугаар сард зохион байгуулаагүй байна.

“Шивээговь сум мэдээ” цахим хаягаар нийт-71 мэдээллийг нийтлэн, бусад байгууллагын 22 мэдээллийг шэйрлэн, шинээр-49 мэдээ мэдээллийг иргэдэд хүргэн ажилласан. 2024 оны 06 дугаар сарын 24-ний байдлаар сумын цахим хуудасны нийт дагагчийн тоон үзүүлэлт- 4404 болсон байна. Сумын хэмжээнд болж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, ажлын байр, арга хэмжээ гэх мэдээллүүдийг тогтмол оруулан ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлт болон халамжийн үйлчилгээг нийт 116 иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 39 иргэнд, халамжийн 10 төрлийн үйлчилгээг 77 иргэнд тус тус хүргэсэн байна. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн 4 төрлийн төсөл арга хэмжээний төсөл болон Нийгмийн халамжийн хэлтсийн Олон нийтийн оролцооны бүлгийн төсөл хүлээн авч байна. 2024 оны 06 дугаар сарын байдлаар ХХҮГ-аас хэрэгжүүлдэг нийтийг хамарсан ажлын 2 дугаар ээлж болох сумын 10 иргэн ажиллаж байна.

ХОЁР. ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Аймгийн 2024 оны 6-р сарын 01-ний өдөр Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг олон улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг “Хөгжөөнт бага нас” уриан дор нэгдсэн үйл ажиллагааны хүрээнд өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлээ.

✓ Тус арга хэмжээгээр “Шивээ-Овоо” ХК, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, 3-р цэцэрлэг, Соёлын төв, Цагдаагийн хэсэг нар Буухиа тэмцээн, 3х3 Сагсан бөмбөгийн тэмцээн, “Эрдэнэсийн арал” нууцыг олох тэмцээн, Унадаг дугуйн уралдаан, “Хөөрхөн дэлхий” гар зургийн уралдаан, Хүүхэд багачуудад зориулсан кино үзвэр зэрэг арга хэмжээг хүүхэд багачуудын дунд амжилттай зохион байгуулсан байна.

Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, хуулийн хэрэгжилтийг хангах, томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх чадавхийг дээшлүүлэх зорилгоор Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн “Хээрийн дадлага” сургалтыг “Орон нутгийн хамгаалалтад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагаа” сэдвээр 3 сумдын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнийг /Шивээговь сумаас 9 иргэн/ хамруулан хураангуй хэлбэрээр 2024 оны 05 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд хээрийн байрлалд зохион байгууллаа.

Говьсүмбэр аймаг байгуулагдсаны 30 жилийн ой, “Боржигин наадам”, “Шивээговь сум байгуулагдсаны 35 жилийн ой” зэрэг ойн баяруудтай холбоотойгоор сумын төсвийн албан байгууллага бүр бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөн гүйцэтгэж байна. 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр байдлаар:

“Илчлэг Шивээ” ААТҮГ нь сумын Нутгийн удирдлагын ордны урд талбайд байрлах “Цэцэрлэгт хүрээлэнг засварлах, өнгө үзэмжийг сайжруулах” ажлыг хийхээр төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний дагуу тус хүрээлэнгийн хашааг сэлгэн янзалж, өнгө будгийг сэргээх, нарнаас саатах саравчнуудыг шинээр байршуулах, лед гэрэлтүүлгэн хэсэг, хүрээлэнгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээр 1000ш мод бутыг суулгах ажлыг хийгээд байна.

Сумын Сонгуулийн хороо, Хэсгийн хороодууд холбогдох хууль дүрэм журмыг мөрдлөг болгон, хуульд заасан хугацааны дагуу ажил чиг үүргээ гүйцэтгэн ажиллаж байна. 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Аймгийн Сонгуулийн хорооны гишүүд сумын Сонгуулийн хороо болон Сонгуулийн хэсгийн хороодод үйл ажиллагааны хяналт шалгалтыг хийж, заавар зөвлөгөө өгөөд байна.

Аймгийн Онцгой комиссын Орлогч даргын 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 53 тоот албан бичгийн дагуу үер усны аюулын талаарх анхааруулга сэрэмжлүүлгийг сумын цахим хуудас болох “Шивээговь сум мэдээ”-гээр дамжуулан 11 удаагийн мэдээллийг олон нийтэд хүргэж, үерт өртөж болзошгүй анхаарвал зохих 5 малчин өрхөд нүүдэл сэлгэх зөвлөгөөг өгч нүүлгүүлсэн. Мөн үерийн аюулаас урьдчилан сэргийлэх үүднээс сумын Онцгой байдлын зардлаас 300.000 төгрөгөөр 200 шуудай худалдан авч, үерийн даланд ашиглах шорооны овоолгыг хийлгэж, аюулгүйн далангийн нөөц бүрдүүлэн ажиллаад байна.

ГУРАВ. ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨВ САНХҮҮГИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

2024 оны 06 дугаар сарын байдлаар сумын төсвийн орлого төлөвлөгөөгөөр 16 төрлийн татварын орлого гүйцэтгэлээр 980,289,396 төгрөг бүрдэж, биелэлтээр 86.75%-тай бүрдсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн 6н байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 2024 оны 06 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 100 хувьтай, байршуулвал зохих 514 мэдээллийг ил тод мэдээллэсэн байна.

ДӨРӨВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

“ШИНЭ-ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”

Сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг, хоршооны зөвлөн туслах багшийн хамтаар сумын 98 малчин өрх болон 280 гаруй иргэдэд Шинэ-хоршоо хөдөлгөөний талаар мэдээлэл, танилцуулга хийн ажиллаа. 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар Шивээговь сумын хэмжээнд шинэчлэн байгуулагдсан 2, шинээр байгуулагдсан 5 хоршоод байна.

Малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмшүүлэхээр 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлтээр 4-н байршилд газар төлөвлөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж 2024 оны 06 сарын 14-ний 04 дугаар тогтоолоор батлуулсан байна. Тус байршлуудад төсөл сонгон шалгаруулалт зарлах тухай сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны А/79 дугаар захирамжийн дагуу сумын төвөөс урагш 2 байршилд, сумын төвөөс баруун тийш 2 байршил нийт 4-н байршилд төсөл сонгон шалгаруулалт явуулах зар мэдээг газрын биржийн цахим систем www.mle.mn-д байршуулсан байна. Мөн Шивээговь сумын мэдээ мэдээллийн нэгдсэн зарын групп болон www.govisumber.gazar.gov.mn-ээр зарыг байршуулж ажилласан байна.

Сумын хэмжээнд 06-р сарын 05-ны байдлаар 15351 мал хорогдоод байна. Үүнд: Адуу-1166, Үхэр-932, Тэмээ-6, Хонь-7556, Ямаа-5691 хорогдоод байна.

Төлийн мэдээ: Ботго-31, Унага-35, Тугал-96, Хурга-3243, Ишиг-2278 Нийт-5683 төл гараад байна. Үүнээс хорогдол: Ботго-0, Унага-9, Тугал-31, Хурга-1066, Ишиг-1282 Нийт-2388 хорогдож, Бойжилт: Ботго-31, Унага-26, Тугал-65, Хурга-2177, Ишиг-996 Нийт-3295 төл бойжиж, бойжилтын хувь 70.6%-тай байна.

ТАВ. ДЭД БҮТЭЦ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

1. - **Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар** батлагдсан 6 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан. Үүнд:
 - ✓ Сургуулийн спорт заалны их засварын ажил
 - ✓ Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний ажил
 - ✓ Хуучин хог хаягдал булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажил
 - ✓ Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах ажил

- ✓ Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцлийг дэмжих /байр засварлах/ ажил
- ✓ Ёслол хүндэтгэлийн өргөө гэр авах ажлуудын тендерийг зарлаад байна.

2024 оны 06 дугаар сарын 11, 13, 20-ны өдрүүдэд сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, 1 дүгээр багийн Засаг дарга, аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын хэлтсийн дарга, ОНХС-ын мэргэжилтэнгийн бүрэлдэхүүн Шивээговь сумын хэмжээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил, 320 хүүхдийн сургуулийн барилгын ажил, босоо тэнхлэгийн замаас сумын төв хүртэлх 6.9 км хатуу хучилттай авто замын ажлуудад хяналт тавьж ажиллаад байна.

Төрийн байгууллагуудад шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах ажлыг 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдөр “Ажил хүлээн авах комисс” 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус ажлыг гүйцэтгэсэн гүйцэтгэгч компаниас тоног төхөөрөмжийг ажлын даалгаврын дагуу 100% хүлээн аваад байна. Шивээговь сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Ус хангамжийн нэмэлт их үүсвэр, шугам сүлжээний автоматжуулалтын ажил, Нийтийн эзэмшлийн 3 дугаар байрны техникийн давхарын шугам сүлжээний их засвар, өргөтгөл шинэчлэл хийх ажил, Цэцэрлэгийн хашааг шинэчлэх ажил, сумын Нэрт багийн нутаг дэвсгэрт Нийтийн биеийн тамирын талбай/хөл бөмбөгийн талбай/ байгуулах зэрэг ажлууд хийгдэж, 30-70%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасныг үндэслэн худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгон зарласан байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан-6

ЗУРГАА. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Боловсролын чиглэлээр: 2024 оны 05 дугаар сарын 24-31-ний хооронд Боловсролын газраас хэрэгжүүлж буй Зүрх сэтгэлийн боловсрол олгох амьдрах ухааны "Малд нүдтэй хүүхэд" хөтөлбөрийг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр ангийн 90 суралцагчдын хүрээнд хэрэгжүүлж, Улсын аварга малчин Б.Ганхуягтай хамтран ажиллав. 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр хүртэл анги дэвших болон төгсөх шалгалтуудыг хуваарийн дагуу авч дүгнээд байна. 2023-2024 оны хичээлийн жилд нийт 824 суралцаж төгсөв.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

“Хог хаягдлын менежмент” болон “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийтийн эзэмшлийн хуваарьт талбайн таригдсан моднуудын цэнэг усалгааг хийх, нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг цэвэрлэх зэрэг ажлуудыг ХХҮГ-аас хэрэгжүүлдэг нийтийг хамарсан ажлын 2 дугаар ээлж болох сумын 10 иргэн өдөр тутам хийж байна. Мөн байгууллагууд 14 хоног тутам өөрийн эзэмшлийн 50м хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэж байна.

2024 оны 06 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд Газрын даамал сумын иргэдийн өөрсдийн эзэмшлийн гражийн газруудад хяналт хийж, ашиглагдахгүй орхигдсон газрын эзэмшигчидтэй холбогдож, эзэмшил газраа зориулалтын дагуу ашиглах, хог хаягдлыг цэвэрлэн орчин тойрныг цэвэрхэн байлгах шаардлагыг тавин ажиллалаа.

Сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 1/280 дугаар тоот албан бичгээр сумын нийт төсвийн байгууллагууд, ААН, иргэдэд бүх нийтийн цэвэрлэгээ хийгдэхийг мэдэгдэж, 06 дугаар сарын 08-ны өдөр бүх нийтийн их цэвэрлэгээг хийхийг үүрэг болгон ажилласан байна.

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

МЭДЭЭГ БЭЛТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН

МЭРГЭЖИЛТЭН

М.ГАНТУЯА